

МОНГОЛ ЭМ ХАДАН ХАЙЛМАЛЫН СУДАЛГААНЫ ТОЙМ

Бай Тана¹, Ваншулан²

(Өвөр Монголын үндэстний их сургуулийн Монгол эм эмнэлгийн дээд сургууль, Монгол эмийн фармакологийн лаборатори)

15164918354@163.com

RESEARCH SUMMARY OF MONGOLIAN MEDICINE *TROGOPTERUS XANTHIPES* MILNE-EDWARDS

Bai Tana¹, Wang Xiu Lan²

College of Mongolian Medicine and Pharmacology, Inner Mongolia University for the Nationalities, Mongolian medicine pharmacology laboratory¹

xiaoxiaoto1994@163.com

Abstract:

Background: *Trogopterus xanthipes* Milne-Edwards (Hadan hailmal) is defecation of Olbo mouse with red and yellow foot in Olbo mouse family. *Trogopterus xanthipes* Milne-Edwards has bitter and little sweet flavor and cool and sharp quality and it has effects such as to remove hot, to stop pain and to make urinate etc.

Purpose: To summarize chemical compounds, pharmacological effects, clinical usage and ancient source notes of *Trogopterus xanthipes* Milne-Edwards.

Method: By analysis method to analyze research articles and ancient source of *Trogopterus xanthipes* Milne-Edwards in China Biological Medical Digest Data-base, Chinese Journals Full Text Data-base and ancient sources of Mongolian traditional medicine

Results and Conclusions: *Trogopterus xanthipes* Milne-Edwards is produced juice from gold, silver, copper, iron, lead and tin on cliff during 4 to 6 months and otherwise *Trogopterus xanthipes* Milne-Edwards is called defecation of olbo mouse. It has many activity chemical compounds, such as nitrogen compound, volatile compound, Triterpenoid, fatty acid, flavone, and microelement and has many pharmacological effects such as anti gastric ulcer, anti inflammation, anti oxidant, anti cerebral ischemic injury, anti cytotoxicity and to improve immunology. In Mongolian traditional medicine, *Trogopterus xanthipes* Milne-Edwards mainly used to treat hot disease of stomach, liver and kidney, synovial disease, gout and rheumatism etc with single medicine and compound recipe ingredients of *Trogopterus xanthipes* Milne-Edwards. In Chinese medicine used to treat disease of digestive system and to stop pain etc.

Key words: Mongolian medicine, *Trogopterus xanthipes* Milne-Edwards, chemical compound, pharmacological effect, ancient source.

Судалгааны үндэслэл: Монгол эм хадан хайлмал бол олбо хулганы язгуурын улаан шар хөлт олбо хулгана *Trogopterus xanthipes* Milne-Edwards-ийн баас мөн. Хадан хайлмал нь гашуун, өчүүхэн давслаг амттай, сэрүүн чанар, хурц эрдэмтэй, халууныг арилгах, өвдөхийг зогсоох, шар усыг хатаах, булчирхайг дарах, махбодийг тэгшитгэх чадалтай нэг зүйлийн үргэлж хэрэглэдэг дан эм болно [1]. Эртний Монгол эмийн сурвалж бичиг “Эрдэнийн цугларал”-д хадан хайлмал бол

сэрүүн хурц бөгөөд элэгний өвчин хуучирснийг арилгана хэмээжээ. “Галбирагч мод”-д шилазадур болбоос шээс чавдагшихийг арилгана, элэгний халууныг арилгахын дээд хэмээн өгүүлсэн байна [2]. Сүүлийн үед хадан хайлмалын талаар Монгол эмийн сурвалж бичигт тэмдэглэж байгаа боловч түүний тухай судалгааны өгүүлэл тун цөөн байна. Иймээс тус өгүүлэлд хадан хайлмалын эртний Монгол эмийн сурвалж бичиг болоод одоо үеийн хамаа бүхий сурвалж бичгийг эмхэтгэн

хадан хайлмалын сурвалж бичгийн судалгаа, химийн бүрэлдэхүүн, фармакологийн үйлдлийн судалгааны ахиц, эмчилгээн дэх хэрэглэлийг системтэйгээр ангилан өгүүлж хадан хайлмалын цаашдын судалгааны суурь болгохыг зорилгоо.

Судалгааны зорилго: Хадан хайлмалын эртний сурвалж бичгийн судалгаа, химийн бүрэлдэхүүн, фармакологийн үйлдлийн судалгаа болон эмчилгээн дэх хэрэглээг системчлэн өгүүлэх.

Судалгааны материал, арга зүй: Тус судалгааг хадан хайлмалын тухай эртний сурвалж бичиг болон Дундад улсын сурвалж бичгийн хөмрөгөөс материал цуглуулан анализын аргаар хийв.

Хадан хайлмалын сурвалж бичгийн судалгааны тойм

Хадан хайлмалын уг гарал нь “Ишийг сацруулах” хэмээхэд ‘ичингүйрэх улаан махбод хадан дээр бууснаар хаднаас илжгийг үүсгэн хадан хайлмал гармой’ хэмээвээ. Түүний бас “Найман гишүүнт”-д ‘дэгжрэлийн цагийн халуунд ээгдсэн хаднаас алт зэрэг гарах уг гарлын махбод болох 6 шим болбоос энгэсэгийн уусмал мэт цуврах түүнийг хадан хайлмал хэмээмой’ хэмээн номлосон болой [2]. “Толь”-д хадан хайлмал гардаг газарт хамт байдаг хулганы баасыг зарим хүн ерийн хулганы баас биш харин олбо хулганы баас мөн гэж ярьдаг. Ингэж хэлэх нь зарим нэг газар орондоо таарах нь байх боловч Амду оронд байдаг олбо хулгана бол их ой шигүүд оршдог. Суганы дундаа сарьсан далавчтай том туулайн чинээ амьтан байдаг байна. Иймээс хадан хайлмал гардаг газрын хулганы баасыг зарим газар орныхон бараграй гэдэг бөгөөд энэ нь шар өнгөт чих хоншоортой хулгана хадан хайлмалыг олж идээд баасан баас мөн болох нь илт байна’ гэжээ [3]. Түүний нэрийг нь агаяа, ава, шилазадур, ахири хэмээдэг болой. Далд нэр нь сансарын улаан боди сэтгэл, эхийн умай цус, хадны даръяаган, хадны цус, хадны рудира, цус адил хадны рагта, газар дээрх өвчнийг дарагч хадны рашаан, махбодийн цус, эрдэнийн шим, сансарын улаан махбод, таван махбодын шимийн эм, элэг цөсний өвчнийг арилгагч, элэгний шим хэмээмой [2]. Хадан хайлмалд криям, хадны шим, цусны рашаан, энгэсэг, даръяаган, умай

цус, газар дээрхийн өвчнийг дарагч, хаднаас төрөгч, өрцний халууныг арилгагч, улаан махбод, элэгний шим гэх мэт илт өгүүлэх нэр буй [4]. Хадан хайлмалыг өөрөөр барагшун гэх ба барагшун нь гашуун, өчүүхэн давслаг амттай, сэрүүн хурц чанартай, халууныг арилгах, махбодыг тэгшитгэх, өвдөхийг зогсоох, шээлгэх, булчирхайг дарах чадалтай. Хадан хайлмалыг жилийн 4 улиралд авч хэрэглэж болох ба авсны дараа хольцыг цэвэрлээд хатааж тавьдаг буюу буцалгаж хөргөсөн ваартай усанд 4 цаг дэвтээж хатаан эмэнд хэрэглэдэг [5]. Хадан хайлмал бол бас халуун өвчин бүхэнд тустай. Ялангуяа ходоод элэг бөөрний халууныг арилгахын дээд гэжээ [2]. Барагшуны аймгийн 5 зүйл бол халуун өвчин хийгээд хий өвчин, гуя хөшихөд тустай. Ходоод, элэг, бөөрний халуун, тулай өвчнийг арилгаж, хаагдсаныг арилгахад голчлон хэрэглэх болмой [6]. “Манжад Давижалбу”-д хадан хайлмалын хандыг библин чихэртэй найруулбал уушиг зүрхний өвчин бүгдийг амирлуулна. Хадан хайлмалыг гүргэм, чихэртэй найруулбал элэгний өвчинд маш сайн. Хадан хайлмалыг цусан өвчин бүгдийг арилгана...’ гэжээ. “Тайлбар Рилба”-д ‘мөнгөн хүдрийн хайлмал бол уяман өвчнийг арилгана. Зэсийн хүдрийн хайлмал бол өгөр цусыг хатаана. Төмрийн хүдрийн хайлмал бол элэгний өвчнийг арилгана. Алтан хүдрийн хайлмал бол шимжүүлнэ’ гэжээ [7]. “Язгуурын үндэс”-д ‘өвчин бүхнийг амирлуулах эм гэвэл 5 зүйлийн жонш ба 5 зүйлийн барагшун мөн. Тэрхүү 5 махбодын хувийг эмээр тэгшитгэх гэсэнд арүр, барагшун бол махбодыг ерөнхийд нь тэгшитгэж байдаг’ болой [8]. Яс чанарын сайн муугийн ялгааг “Үндэс”-д хадан хайлмал бол шороогүй хар өнгөтэй шинхэг амтлагдах юм хэмээжээ. “Цагийн хүрд”-д ямар нэгэн хадан хайлмалаар эс арилах өвчин гэж газар дэлхий дээр байхгүй гэсэн байдаг [9].

Одоогоор хадан хайлмал гэж хэрэглэж байгаа уул амьтанд хар цагаан олбо хулгана, Түвд уутлаг туулай, уутлаг туулай, улаан чихт уутлаг туулай, том чихт уутлаг туулай, Монгол уутлаг туулай, өндөрлөгийн уутлаг туулай, зүүн хойд уутлаг туулай зэрэг амьтны баасыг адил бус газарт хадан хайлмалыг орлуулан хэрэглэж байна.

Хадан хайлмалын эмийн таваарын төрөл

зүйл олон байна. Ерөнхийдөө хэсэгт хадан хайлмал болон мөхлөгт хадан хайлмал гэж хоёр том зүйлд хуваана. Хэсэгт хадан хайлмалын хэсэгтэй харавтар улаавтар өнгөтэй, гялгар, тослог зөөлөн, хольцгүй нь яс чанар сайн. Мөхлөгт хадан хайлмалын гадаргуу нь арзгар бөгөөд харавтар улбар өнгөтэй, дотроо шарангуй ногоон өнгөтэй, хөнгөн хольцгүй нь яс чанар сайн [7].

Хадан хайлмалыг дөрвөн зүйлээр өгүүлсэн нь “Рашааны найман бүлэг”-т ‘дорно, өмнө, өрнө, умар зэрэг хаанаас ч гарах болой. Хадан агуйн хонхорт байдаг нь рашаан хайлагдаж цуварсан элдэв зүйлийн эрдэм болмой’ хэмээвээ. Үүний бас язгуурт дөрвөн эхийн Рагта дусал хэмээн өгүүлж дөрвөн зүгийн дөрвөн эхийн мөн чанар бүхий дөрвөн эрдэнийн шүүс цуварсан нь алт, мөнгө, зэс, төмөр зэрэг дөрвөн өнгөтэй гармой хэмээсэн ба таван зүйлээр номлосон нь “Цогт дөрвөн үндэсний зөвшөөрлөөр болбоос тугалга хэмээх нь цагаан тугалга, хар тугалга болой” хэмээжээ. Энэ нь хар цагааны ялгал төдий боловч тугалга учраас үүний бас нэг нь хураангуйлаад тав болгосон болой. “Кардавын гол” номонд ‘хадан хайлмал болбоос тэгжээлийн цагийн нарнаа маш ээгдсэнээр алт, мөнгө, зэс, төмөр, цагаан тугалга, хар тугалга зэрэг зургаа болой. Эдгээр нь тус тусынхаа шүүсийг цувруулдаг болой’ гэжээ [2].

Хадан хайлмалын химийн бүрэлдэхүүний судалгааны тойм:

Хадан хайлмалд олон төрлийн химийн бүрэлдэхүүн агуулагддаг. Хадан хайлмалын химийн бүрэлдэхүүний судалгаа нь ХХ зууны 1980 оны сүүл үеэс эхэлсэн байдаг.

1. Азот агуулсан нэгдэл: Яан дун мин нар 1987 онд химийн арга, спектроанализын аргыг хэрэглэн хадан хайлмал дотроос урацил, уреа, 6-оксипурин, аллантаин, L-тирозин, шээсний хүчил зэргийг олжээ [10].

2. Тритерпен: Японы эрдэмтэн Ацуши Нумата нарын судалгаагаар хадан хайлмалд алкид резин, томентын хүчил-3-О₂-р-кумарын хүчлийн эстер, томент-3-О₂-анти-р-кумарын хүчлийн эстер, маслиний хүчил-3-О₂-анти-р-кумарын хүчлийн эстер, 2-гидрокси урсолын хүчил, маслиний хүчил, урсолын хүчил, зускапын хүчил, томентын хүчил агуулагдаж байжээ. 1990 онд бас түүний дотроос

серратагений хүчил, faeces trogopterus гурван мөөгний хүчил I, II, III-ийг тус тус ялган авсан байна [11-12].

3. Флавон: флавоны төрлийн нэгдэл нь хадан хайлмалын химийн бүрэлдэхүүний нэг болно. Гэвч түүний тухай судалгаа харьцангуй цөөн байдаг. Жиао юу нар хадан хайлмалаас анх удаа хинокифлавон, аментофлавоныг ялган авсан байна [13].

4. Тосны хүчил: Ян чи нар хадан хайлмал дотроос 14 дикарбоксилийн хүчил (8.843%), линолын хүчил (7.770%), цетилийн хүчил (5.538%) зэрэг 15 төрлийн тосны хүчлийг байна [14].

5. Дэгдэмхий нэгдэл: Жү сиан юу нар хадан хайлмалын петролейны эфирийн хэсгээс 21 нэгдэл ялган авсан ба үүнд голдуу эерэг 41 алкан спирт (21.72%), склареол (14.08%), цетилийн хүчил (9.11%) байна. Үүний дотор спиртийн төрлийн нэгдэл 40%-ээс дээш хувийг эзэлж байжээ [15]. Чен мин нар Шан си, Шан ян-ы хээрийн хадан хайлмал дотроос 65 төрлийн дэгдэмхий нэгдлийг олсон ба голдуу транс скуален (12.14%), цетилийн хүчил (8.2-7%), дан (2-гесксил) фталат ди шоргоолжны хүчлийн нийлмэл эфир (8.25%), дибензойны хүчил дибутил нийлмэл эфир (3.80%), тетрадеканойны хүчил (3.04%), гексадеканол (2.94%) байсан байна. Хэбэй, Лай шүгийн хээрийн хадан хайлмалаас цетар комфор (12.31%), кариофиллен (7.5%), 8,13-гликол-ладанум-14-алкен (7.22%), 1,5,9,9-тетраметил-1,4,7-цагариг-11 алкен триен (6.09%), гермакрен D4 (25%), тужоппен (2.58%) гэх мэт 85 зүйлийн дэгдэмхий нэгдлийг олжээ. Зарим судлаачид хадан хайлмалын дэгдэмхий нэгдэл нь хэвтээ арцын хүрээн доторхи дэгдэмхий нэгдлүүдтэй адилавартай байна гэж үзжээ [16-17].

6. Бусад зүйл: Жоу жу нар ацетонд хандлангарганавсанхаданхадмалынханднаас 3 нэгдлийг ялган авчээ. Спектроскопийн аргаар 3-гидрокси-(3-гидроксипени)-бензе-непропанол, транс-2-(3,5-ди гидроксибензил)-3-(3-дигидроксибензил)-ү-бутиролактон болон токоферил хинон зэргийг тус тус хадан хайлмалаас гарган авчээ [18]. 1990 онд хийгдсэн судалгаагаар хадан хайлмалд фенолын хүчил, дан монотерпен, дитерпеноидийн хүчил, катехол, бензойны

хүчил, гидроксibenзойны хүчил, протокатехин, faeces trogopterum дитерпен, 5-метокси-7-гидроксикумарин агуулагдаж байсан байна [19]. Ли чан хадан хайлмалын дотроос 20 нэгдлийг ялгаж түүний доторхи эерэг 27 алкан, дигидроген ситостанол, эпифриеделинол, β 2 ситостерол, урсолын хүчил, каротин зэрэг 6 нэгдлийн бүтцийг тогтоожээ. Урсолын хүчлээс гадна бусад 5 нэгдлийг анх удаа хадан хайлмал дотроос ялган авчээ [20]. Хадан хайлмалын эмийн материал түүний номхотгосон хэлбэрт Ca, Mg, Fe элбэг агуулагддаг ба Ca, Mg-ийн агууламж нь хадан хайлмалд өндөр байдаг байна. Номхотгосон хэлбэр нь Al-ны уусан гарахыг багасгана [21]. Жан гүй лиэн нар хадан хайлмалд Zn-ын агуулагдац бага харин гадна Fe, Se, Cu элбэг агуулагддаг болохыг илрүүлсэн байна [22].

Хадан хайлмалын үйлдлийн судалгааны тойм:

1. DPPH чөлөөт бүлгийг ангижруулах нь: Хадан хайлмалын флавоны уусмалыг цэвэршүүлсний дараа DPPH чөлөөт бүлгийг ангижруулах чадвар 5.62% дээшилж, исэлдэхийг эсэргүүцэх чадвар нь нэмэгдсэн байна [23].

2. Үрэвслийг дарах үйлдэл: Ван ши жиу нарын судалгаагаар хадан хайлмалын этил ацетатаар гарган авсан ханд нь үрэвсэлт нэхдэсийн үрийн шингэний булчирхайн эд E(PGE)-ийн агууламжийг бууруулна. Гэвч жижиг хулганы цусны сийвэнгийн кортикостероны хэмжээнд илэрхий нөлөөгүй байдаг. Үүнээс үзэхэд хадан хайлмалын үрэвслийг дарах үйлдэл нь PGE нийлэгжлийг хориглохтой холбоотой байж болох юм [24].

3. Ходоодны шархлааны эсрэг үйлдэл: Ли чин мин нар shau эмгэг загвар ба резерпиний эмгэг загвараар хадан хайлмалын ходоодны салстыг хамгаалах үйлдлийн ашигт бүрэлдэхүүн болон түүний үйлдлийн уг ёсыг судлахаар дамжин хадан хайлмалын ходоодны хүчлийн шүүрэхийг хориглож ходоодны салстыг хамгаалж, ходоодны шархлаанаас урьдчилан сэргийлэх үйлдэлтэй болохыг тогтоожээ [25]. Хадан хайлмалын ходоодны салстыг хамгаалах үйлдэл нь ходоодны ханыг нийлэгжүүлэх нялцгай шингэний хэмжээг нэмэгдүүлэх болон ходоодны салстын PGE2-ийн шүүрэлтийг

хориглохтой хамаатай болохыг судалгаагаар тогтоожээ [26].

4. Эс хордуулах үйлдлийн судалгаа: Судлаачид хадан хайлмалын дөрвөн төрлийн тритерпен эс хордуулах үйлдэлтэй болохыг илрүүлсэн байна [27].

5. Дархлаа сайжруулах үйлдэл: Хадан хайлмалын усан ханд нь эрүүл NIH жижиг хулганы Т эсийн лимфоцит эс боловсрох чадварыг илэрхий дээшлүүлж, ALS-ээр эсийн дархлааг бууруулсан жижиг хулганы Ts эсийн хэмжээг эрүүл хулганы Ts эсийн хэмжээтэй адил түвшинд хүргэн дархлааг дээшлүүлэх үйлдэл үзүүлсэн байна [28].

6. Тархины цусан хангамж дутагдлыг эсэргүүцэх үйлдэл: Хадан хайлмалын усан ханд нь тархины цусан хангамж дутагдсан жижиг хулганы амьдрах хугацааг илэрхий уртасгаж, хархны тархинд агуулагдах усны хэмжээ болон тархины индексийг багасган, тархины нэхдэсийн MDA-ийн агууламжийг бууруулж, SOD-ийн идэвхит чанарыг дээшлүүлснээр хадан хайлмал нь зохих хэмжээний тархинд цус дутагдахыг эсэргүүцэх үйлдэлтэй гэж үзсэн байна [29].

Хадан хайлмалын эмчилгээн дэх хэрэглэлийн тухай тойм:

Хадан хайлмалд агуулагдах нэгдлүүдийг олон зүйлийн өвчнийг анагаахад хэрэглэдэг бөгөөд голдуу өвдөхийг зогсоох ба шингээлтийн системийн өвчин, ходоод, элэг, бөөрний халууныг засдаг байна.

1. Хятадын анагаах ухаанд :

1) Шингээлтийн чанартай шархлааг засах: Ван жи хуа нар өөрөө найруулсан хадан хайлмалын тангаар шингээлтийн чанарт шархлааг 30 жишээ өвчтөнг эмнэн зассан байна. Харьцуулах дугуйланд ранитидин 150мг-аар өдөрт 2 удаа уулгасан ба үр дүнд өөрөө найруулсан хадан хайлмалын тангаар зассан 30 өвчтөнийн 27 өвчтөн эдгэрч, 2 өвчтөн сайжирч, нэг өвчтөнд үйлдэл гарсангүй. Хадан хайлмалын ерөнхий эмчилгээний үйлчилсэн норм нь 96.7% байв. Харьцуулах дугуйлангийн 30 өвчтөнд 16 өвчтөн эдгэрч, 9 өвчтөн сайжирч, 5 өвчтөнд үйлдэл гарсангүй. Ерөнхий эмчилгээний үйлчилсэн норм 83.3% байв. Хоёр бүлэгт эдгэрсэн норм болон ерөнхий эмчилгээний үйлчилсэн норм илэрхий зөрөөтэй байжээ ($p < 0.01$) [30].

2) Зөөлөн эдийн гэмтлийг засах: Сиа вэй мин нар хадан хайлмал орсон ханд эмээр 256 өвчтөнийг зассанд 31 өвчтөнд үйлдэлтэй (12.11%) байсан ба 214 өвчтөнд илэрхий үйлдэлтэй (83.5%), 11 өвчтөнд үйлдэлгүй (4.3%) байна [31].

3) Бусад: эмчилгээн дээр хадан хайлмалыг бусад эмтэй хавсарган удаан чанартай агших чанартай ходоодны үрэвсэл, эмэгтэйчүүдийн өвчин, аарцгийн хөндийн үрэвслийг эмнэн засаад зохих хэмжээний амжилт олжээ. Хадан хайлмал орсон ханд эмээр хавдрын өвдөлтөөс бусад өвдөлттэй 114 өвчтөнийг засч 99 өвчтөний өвдөлтийг бүрмөсөн намдааж, 11 өвчтөний өвдөлтийг түр намдааж, 3 өвчтөний өвдөлтийг хөнгөн намдааж, 1 өвчтөнд үйлдэл гараагүй байна [32-34].

Монголын анагаах ухаанд:

Хадан хайлмал орсон найрлага хадан хайлмал-5 тангаар тулай өвчнийг засч, хадан хайлмал-9 тангаар ходоод, гэдэс зэрэг савын цус шарын халууныг арилгана. Бөөрний халууны гүргэм-7-д хавсарган бөөрний халууныг арилгадаг. Хадан хайлмалын ханданд гол эм болгоож элэгний 13 зүйлийн халуун өвчинд тустай бөгөөд нүдний өвчин, тулай, хэрх, шар усны өвчинд ч тустай байдаг юм. Шар усыг хатаах, халууныг арилгах, өвдөхийг зогсоох чадалтай тул тулай, хэрх, үе гишүү өвдөх, шар усны өвчинд тустай. Догол өвс, өргөст арц мэтийн шар усыг арилгаж хатаах эмтэй хавсаргаж догол өвс-3 танд хөл эм болгож хэрэглэнэ. Булчирхайг дарж халууныг арилгах чадалтай тул булчирхай хавдаж өгөрлөн халуурахад тустай. Гагцаар түрхлэг эм болгох буюу хар жилээ мэтийн хавдарыг хариулж, шар усыг арилгах эм болон хонлэн мэтийн муу цусыг хатаах эмтэй хавсаргаж түрхлэг эм болгон хэрэглэнэ [1,7].

Хэлцэмж:

Эртний Монгол эмийн бичигт тэмдэглэсэнээр хадан хайлмал бол алт, мөнгө, зэс, төмөр, хар тугалга, цагаан тугалга зэрэг 6 зүйлийн бодисын тус тусын шүүсэн дэх дэгжээл цагийн (4 сарын 16 – 6 сарын 15) халуунд ээгдэн хаднаас цувиран тус тусын хайлмал болж, тус тусын амт, чанар, чадал эрдмээрээ зохих өвчнийг арилган засдаг байна. Бас зарим сурвалж бичигт хадан хайлмал гардаг олбо

хулганын баас зарим орон газарт бараграй гэж.. тэр нь шар өнгөт чих хоншоортой хулгана хадан хайлмалыг олж идээд баасан баас нь мөн гэж тэмдэглэж байна. “Дээдсийн таалал чимэг”-т Олбо хулганы баасыг хадан хайлмал гэж таньж байгаа нь эндүүрэгдсэн байна. Хадан хайлмалын эмчилгээнд хэрэглэх эмийн материал нь эндүүрэгдэж байгаа ба яс чанар нь ч янз бүр байх нь түүний биологийн идэвхийг сулруулж мэднэ. Тиймээс хадан хайлмалын эмийн материалын стандартын судалгааг улам нэг алхам судлах нь чухал байна.

Хадан хайлмал нь ходоодны хүчлийн шүүрлийг хориглож ходоодны ханыг нийлэгжүүлэх нялцгай шингэнийг нэмэгдүүлэх болон ходоодны салстын PGE2-ын шүүрлийг хориглохоор дамжин ходоодны салстыг хамгаалж ходоодны шархлааг эмнэн засдаг. Хадан хайлмал нь Монгол анагаах ухаанд сэрүүн чанартай гашуун өчүүхэн давслаг амттай, халууныг арилгаж, махбодыг тэгштгэн өвдөхийг зогсоох чадалтай байж ходоодны халууныг арилгаж, ходоодны шархлаа өвдөхийг намдааж махбодыг тэгшитгэдгээс ходоодны шархлааг сайн засч одоо үеийн судалгааны уг ёстой тохирч байна.

Хадан хайлмал нь **тархины цус дутагдсан** нэхдэсийн MDA-ийн хэмжээг бууруулж, SOD-ийн идэвхит чанарыг дээшлүүлэхээр дамжин хулганы амьдрах цагийг уртатган, тархин дах усны хэмжээ ба тархины индексийг бууруулж, тархины цус дутагдахыг эсэргүүцэж байна. Тархинд цус дутагдах өвчин бол зүрхний цус дүүрэх хүч буурах, зүрхэнд цус дутагдах зэргээс болж тархинд очих цусны хэмжээ багасч тархинд цус дутах өвчин үүснэ. Үүнд хадан хайлмал нь зүрхэн халууныг арилган махбодыг тэгшитгэдгээс зүрхний тамирыг сайжруулан зүрхний ажиллагааг хэвийн болгож тархинд хүрэх цусны хэмжээг гүйцэт болгосноос тус өвчнийг сайн эмнэн засдаг байж болох юм.

Дүгнэлт:

1. Хадан хайлмал бол алт, мөнгө, зэс, төмөр, хар тугалга, цагаан тугалга зэрэг 6 зүйлийн бодисын тус тусын шүүсэн дэх дэгжээл цагийн халуунд ээгдэн хаднаас цувиран тус тусын хайлмал болох бөгөөд хадан хайлмал нь олбо хулгана хадан хайлмалыг олж идээд

баасан баас мөн. Хадан хайлмалыг зарим оронд хар цагаан олбо хулгана, Түвд уутлаг туулай гэх мэт амьтны баасаар орлуулан хэрэглэж байна. Хадан хайлмалд олон арвин далд нэр болон өгүүлэх нэр байдаг ч үргэлж хэрэглэдэг нэр нь барагшун болон хадан хайлмал болно. Хадан хайлмал гашуун, өчүүхэн давслаг амттай, сэрүүн хурц чанартай, халууныг арилгах, махбодыг тэгшитгэх, өвдөхийг зогсоох, шээлгэх, булчирхайг дарах чадалтай. Олбо хулгана нь хадан хайлмал баасыг хадан хайлмал гэж хэрэглэж байгаа боловч эртний сурвалж бичигт тэмдэглэснээс үзвэл эндүүрсэн эсэх нь тодорхой биш, иймээс хадан хайлмалын тухай гүнзгийрүүлэн судлах чухалтай.

2. Хадан хайлмалд голдуу флаван, тритерпен, дэгдэмхий чанартай бүрэлдэхүүн, өөхөн хүчил, органик бус хүчил, азот агуулсан нэгдэл, витамин, бичил элемент зэргийг агуулах бөгөөд хадан хайлмал нь үрэвслийг дарж исэлдэхийг эсэргүүцэн, дархлааг сайжруулж, ходоодны шархлааны эсрэг, тархинд цус дутагдахын эсрэг ба эс хордуулах үйлдэлтэй.

3. Хадан хайлмалыг Монгол анагаах ухааны эмчилгээнд ходоод, элэг, бөөрний халуун өвчин, тулай өвчин, нүдний өвчин, хэрх шар усны өвчин, үе гишүү өвдөх болон булчирхай хавдаж өгөрлөн халуурахад дан эмийн хэлбэрээр болон найрлага эмэнд хөл эм болгож хавсарсан хэлбэрээр хэрэглэдэг байна. Харин Хятад эмнэлэгт хадан хайлмалыг шингээлтийн системийн өвчинг засах, эмэгтэйчүүдийн өвчинг засах, аарцгийн хөндийн үрэвслийн эсрэг, өвдөлт намдаахад хэрэглэж байна.

Ном зүй:

1. Лувсан “Монгол эмийн судлал”, [М] Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2006 он, 263-264.

2. Данзанпунзаг “Эмийн хиргүй болор эрх”, [М] Улаанхад, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2001 он, 155-162

3. Лувсан Монгол эмийн ухаантан Лувсангийн эрдэм шинжилгээний бүтээл-5 “Эм таних ухаан”, [М] Улаанхад, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2011 он, 18-19.

4. Сүнли “Цагаан болор толь”, [М] Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2014 он, 18-19.

5. Гомбожав “Элдэв чухал хэрэгт”, [М] Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1999 он, 93-94.

6. Жигмэд Данзанжамц “Тунгагажид”, [М] Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1999 он, 36.

7. Лувсан Монгол эмийн ухаантан Лувсангийн эрдэм шинжилгээний бүтээл-3 “Монгол эмийн ойллого” (дэд), [М] Улаанхад, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2011 он, 1436-1442.

8. Сүнли “Алтан хадмал”, [М] Хөххот, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 2015 он, 559-561.

9. Лувсан Монгол эмийн ухаантан Лувсангийн эрдэм шинжилгээний бүтээл-6 “Дээдсийн таалал чимэг”, [М] Улаанхад, Өвөр Монголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо, 2011 он, 58-59.

10. 杨东明, 苏世文, 李铎, 等. 五灵脂活性成分的研究 [J]. 药学学报, 1987 (10): 756-76.

11. Atsushi Numata, Peiming Yang, Hika Takashi, et al. Cytotoxic triterpenes from a Chinese medicine [J], Goreishi. Chem. Pharm. Bull, 1989; 37(3): 648-651.

12. Atsushi Numata, Chika Takahashi, Tamie Miyamoto, et al. New triterpenes from a Chinese medicine [J], Goreishi. Chem. Pharm. Bull, 1990, 38(4): 942-944.

13. 焦玉, 李丹艺, 刘晓秋, 等. 五灵脂中两个黄酮成分的提取分离与薄层色谱鉴别 [J]. 中药材, 2009, 32(7): 1039-1041.

14. 杨琦, 赵岩, 陈文学, 等. 五灵脂的脂溶性成分 GC-MS 分析 [J]. 中国现代中药, 2010, 12(10): 19-24.

15. 朱翔宇, 杨莲菊, 李春. 五灵脂石油醚部分化学成分的气相色谱-质谱联用分析 [J]. 中国实验方剂学杂志, 2010, 16(4): 18-20.

16. 程明, 王宏洁, 杨连菊, 等. 陕西山阳野生五灵脂挥发性成分 GC-MS 研究 [J]. 中国实验方剂学杂志, 2011, 17(19): 97-100.

17. 程明, 杨立新, 杨连菊, 等. 河北涑水野生五灵脂挥发性成分 GC-MS 研究 [J]. 中国中药杂志, 2011, 36(24): 3480-3483.

18. 赵君,戴丽香,雷婷,等.中药五灵脂的化学成分研究〔J〕.天然产物研究与开发,2010(22):541-543.
19. 仲崇林,李焕荣,邓明鲁,等.五灵脂化学成分的研究〔J〕.中草药,1990 1:11.
20.]李强,陆蕴如等,五灵脂化学成分的研究〔J〕中国药学杂志,199934(8):514-516
21.]刘文案,刘倩平,李庆明,等.五灵脂及其炮制品的微量元素含量测定〔J〕.广东微量元素科学,2002(11):59-60.
22. 张桂莲,郭梅凤,李美鲜.五灵脂等5种中草药铜、铁、锌、硒含量分析〔J〕.包头医学院学报,2012(3):27-28.
23. 杨莲琴,徐秀文,任雪峰,安红钢,吴冬青,五灵脂总黄酮纯化及清除DPPH自由基,光谱实验室,2013,11,30(6):3102-3108.
24. 张桂莲,郭梅凤,李美鲜.五灵脂等5种中草药铜、铁、锌、硒含量分析〔J〕.包头医学院学报,2012(3):27-28.
25. 程志安,李庆明,王雄文.五灵脂萃取物对实验性胃溃疡及胃酸分泌的作用〔J〕.中山医科大学学报,1997(1):47-50.
26. 王雄文,刘文姿,黎成科,等.五灵脂B1对大鼠胃壁结合黏液量及胃黏膜PGE2的影响〔J〕.广东药学院学报,2004(5):515-516.
27. Atsushi Numata,Peiming Yang,Chinka Takahashi, et al.Cytotoxic Triterpenes from a Chinese Medicine〔J〕.Chem Pharm Bull, 1989, 37(3): 648.
28. 樊良卿,杨锋,胡利平等,丹皮等活血化瘀药对细胞免疫功能低下小鼠的免疫调节作用〔J〕.浙江中医杂志,1992,27(4):180-182.
29. 卜淑敏,贾卯花,曲运波,五灵脂对小鼠和大鼠脑缺血的保护作用〔J〕.山西大学学报(自然科学版)2000,23(3):257-259.
30. 王芝华,郑昱.五灵脂汤治疗消化性溃疡30例〔J〕.中国中西医结合消化杂志,2002(4):239-240.
31.]范跃峰,夏卫民.五灵脂散治疗软组织损伤256例〔J〕.中医外治杂志,2000(3):45.
32. 李捷.五灵脂研究进展〔J〕.医学信息,2009(9):2258-2260.
33. 唐绪刚,黄文权.五灵脂药理及临床应用概述〔J〕.中国中医急症,2008 1:101-102.
34. 邱祖萍.3921 镇痛膏治疗非癌性疼痛114例〔J〕.中医外治杂志,2001(2):9-10.

*Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор Э.Сэлэнгэ*